



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 362

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 2 нэрийн нийт 80,100,000.00 (наян сая нэг зуун мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 38,000,000.00 (гучин найман сая) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Сонгуулийн ерөнхий хорооны дарга Д.Баяндүүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132007742

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн
362... дугаар тогтоолын хавсралт

Сонгуулийн ерөнхий хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэгдэл өртөггүй,
ашиглах хугацааг сунгаж үнийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Цаашид ашиглах хугацаа (жилээр)
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт үнэ (төгрөг)	
1	Хьюндай старех- Н-1, 03-29 УНУ	2013/ 2013	42,200,000.00	1	42,200,000.00	20,000,000.00	1	20,000,000.00	5
2	KIA Bongo-III /Бүхээгтэй/, 03- 25 УНУ	2013/ 2013	37,900,000.00	1	37,900,000.00	18,000,000.00	1	18,000,000.00	5
	Нийт дүн				80,100,000.00 /наян сая нэг зуун мянган/			38,000,000.00 /гучин найман сая/	